


Үндэсний хөгжлийн газрын даргын
2020 оны 06 сарын 18 өдрийн 1.5 тоот
тушаалын хавсралт



ТӨСЛИЙН САНХҮҮГИЙН ҮР АШГИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Аргачлалын зорилго нь төслийг хэрэгжүүлснээр анхны хөрөнгө оруулалтаа нөхөж, санхүүгийн хувьд үр ашигтай ажиллах боломжтой эсэхийг тодорхойлоход оршино.
- 1.2. Энэхүү аргачлалыг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр /цаашид УХОХ гэх/-т тусгах хөрөнгө оруулалтын төслийн санхүүгийн тооцоолол, хөрөнгө оруулалтын өгөөж, санхүүгийн үр ашгийн шинжилгээ хийх, шинжилгээний үр дүнд үндэслэн эрэмбэлэх, сонгоход ашиглана.

ХОЁР. НЭР ТОМЬЁНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1. Энэхүү аргачлалд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - “хөрөнгө оруулалтын өгөөж” гэж төсөлд оруулсан хөрөнгө оруулалтын үр дүнд бий болох мөнгөн дүнгээр илэрхийлж болохуйц ашиг болон алдагдлыг;
 - “санхүүгийн үр ашгийн шинжилгээ” гэж төсөлд хөрөнгө оруулалт хийж, түүний үр дүнд бий болох санхүүгийн үр ашиг, түүнийг хэрэгжүүлэх боломжтойг тодорхойлох шинжилгээг;
 - “анхны хөрөнгө оруулалт” гэж төслийг эхлүүлэхэд шаардлагатай мөнгөн орох урсгалыг;
 - “орлого” гэж бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх буюу нийлүүлэх, ажил, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанаас тухайн хугацаанд бий болсон хөрөнгийн дотогш урсгалыг;
 - “зардал” гэж үйл ажиллагаа явуулахтай холбогдон гарч байгаа хөдөлмөр, хөрөнгийн зарцуулалтыг мөнгөн дүнгээр илэрхийлсэн хэмжээг;
 - “санхүүжилтийн хуваарь” гэж зорилго, зорилт, үе шатуудын дагуу шаардлагатай хөрөнгө оруулалт, зарцуулах мөнгөний хуваарийг;
 - “санхүүгийн хорогдуулалтын хувь (financial discount rate)” гэж ирээдүйн мөнгөн урсгалуудын өнөөгийн үнэ цэнийг олоход ашигладаг хүүгийн түвшинг;
 - “капиталын жигнэсэн дундаж өртөг” гэж төслийг санхүүжүүлэх эх үүсвэрүүдэд төлөх шаардлагатай хүүлөгөөжийн жигнэсэн дундаж хувийг;
 - “алдагдсан боломжийн өртөг” гэж өөр сонголт хийсэн бол олж болох байсан мөнгөний хэмжээ буюу тухайн сонголтыг хийснээр алдаж буй орлого, ашгийн хэмжээг;
 - “мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ” нь өнөөдөр байгаа мөнгө тодорхой цаг хугацааны эцэст (ирээдүйн үнэ цэнэ) хэдий хэмжээтэй болж өсөхийг, ирээдүйд тодорхой хэмжээний мөнгөтэй болохын тулд өнөөдөр (өнөөгийн үнэ цэнэ) хэдэн төгрөг зарцуулахыг харуулна.
 - “мөнгөний өнөөгийн үнэ цэнэ” гэж тодорхой хүү болон хугацаанд суурилан тооцсон хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг;
 - “мөнгөний ирээдүйн үнэ цэнэ” гэж тодорхой хүү болон хугацаанд суурилан тооцсон одоогийн хөрөнгийн ирээдүйн үнэ цэнийг;

- "өнөөгийн цэвэр үнэ цэнэ" нь хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлснээр бий болох ирээдүйн мөнгөн урсгал нь цаг хугацааны хүчин зүйлийг харгалзан тооцоход зардлаа хэрхэн нөхөж байгааг харуулна.

ГУРАВ. ТӨСЛИЙН САНХҮҮГИЙН ҮР АШГИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙХЭД БАРИМТЛАХ ЗАРЧИМ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 3.1. Төслийн орлого, зардал нь төслийн хүрээнд хийгдсэн судалгаа, төлөвлөлтүүдийн үр дүнд үндэслэх тул санхүүгийн тооцооллыг хийхээс өмнө төслийн зорилго, зорилт, зах зээлийн боломж, бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл, үнэ тариф, шаардлагатай тоног төхөөрөмж, ажиллах хүч, түүхий эд, материалыг тодорхойлох болон төсөлтэй холбоотой бүх судалгаа, төлөвлөлтүүд бүрэн хийгдсэн байна.
 - 3.2. Төслийн санхүүгийн үр ашгийн шинжилгээг хийхдээ түүний үр дүнд нөлөөлөх дараах хүчин зүйлүүдийг харгалзан үзэх ёстой. Үүнд:
 - Төсөл хэрэгжих орчны өнөөгийн төлөв байдал
 - Эрэлт, хэрэгцээний тогтвортой байдал
 - Нөөцийн хязгаарлагдмал байдал
 - Төслийг цаашид өргөжүүлэх боломж
 - Санхүүжилтийн эх үүсвэрийн хүрэлцээтэй байдалТоолийн үргэлжлэх хугацаа
 - Төслийн эрсдэлийн түвшин
- 3.3. Төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлохдоо нэг эх үүсвэрээс дангаар санхүүжүүлэх боломжтой ч, учирч болох эрсдэлийг хуваах зорилгоор өөр эх үүсвэрүүдтэй хослуулан санхүүжүүлэх нь илүү үр ашигтай байдаг гэдгийг харгалзан үзнэ.

ДӨРӨВ. ТӨСЛИЙН САНХҮҮГИЙН ҮР АШГИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ДАРААЛАЛ, ҮЕ ШАТ

- 4.1. Төслийн санхүүгийн үр ашгийн шинжилгээг дараах үе шатуудаар гүйцэтгэнэ. Үүнд:
 - 4.1.1. **Үе шат 1. Тооцооллын урьдчилсан нөхцөл, суурь өгөгдлүүдийг тодорхойлох.** Үүнд: шинжилгээний хугацаа, технологийн карт, нэгж зардлын үнэ тарифууд, бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл тус бүрээр үнэ, тарифууд, валютын ханш г.м.
 - 4.1.2. **Үе шат 2. Төслийн анхны хөрөнгө оруулалтын зардлыг тооцоолох.** Төслийн анхны хөрөнгө оруулалт нь түүний төлөвлөлт, бэлтгэл үйл ажиллагаатай холбоотой зардлууд, барилга, байгууламж, дэд бүтэц, машин, техник, тоног төхөөрөмжтэй холбоотой зардлууд, тээврийн хэрэгсэл, компьютер, бусад хэрэгсэл, тавилга, эд хогшил, биет бус хөрөнгө, санхүүжилтийн өртөг, эргэлтийн хөрөнгийн зардлаас бүрдэх ба Хавсралт 1-д үзүүлсэн маягтын дагуу тухайн төслийн зорилго зорилтуудын хүрээнд, түүний онцлогт тохирсон байдлаар бэлтгэнэ.
 - 4.1.3. **Үе шат 3. Төслийн орлого, зардлын тооцооллыг хийх.** Энэ хэсэгт төслийн орлого, зардлын жил бүрээр хийх ба инфляц болон үнийн харьцангуй өөрчлөлтийг харгалзан тодорхой үеүдээр үечилсэн байдлаар тооцоог шинэчилж болно. Төслийн зардлын тооцооллыг Хавсралт 2-т заасны дагуу, төслийн орлогын тооцооллыг Хавсралт 3-т заасны дагуу хийнэ. Хавсралтуудад орлого, зардлын төрлийг жишээ болгон авсан ба тэдгээр нь төслийн онцлогоос шалтгаалан өөрчлөгдөнө.
 - 4.1.4. **Үе шат 4. Санхүүжилтийн хуваарийг гаргах.** Төслийн төлөвлөлтөд суурилсан санхүүгийн суурь тооцоололд үндэслэн санхүүжилтийн хуваарийг төслийн үе шат, зорилт нэг бүрээр Хавсралт 4-т заасны дагуу гаргана.

- 4.1.5. **Үе шат 5. Санхүүжүүлэх эх үүсвэрийг төлөвлөх.** Санхүүжилтийн хуваарийн дагуу санхүүжүүлэх эх үүсвэрүүдийн тавигдах шаардлага, санхүүжүүлэх нөхцөлүүдийг харьцуулан судалж, боломжит хувилбаруудыг тодорхойлно.
- 4.1.6. **Үе шат 6. Санхүүгийн үр ашгийн шинжилгээ хийх хугацааг тодорхойлох.** Төслийн онцлогоос хамааран санхүү, хөрөнгө оруулалтын шинжилгээ хийх хугацаа өөр өөр байх хэдий ч төслийн гол үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаатай нийцсэн байх ба ихэвчлэн 10-с дээш жилийн хугацаагаар тооцоолно. Доорх хүснэгтэд зарим салбарын төслүүдийн жишиг хугацааг үзүүлэв.

Төслүүд/салбараар	Жил
Эрчим хүч	25
Байгаль орчин,ус	30
Төмөр зам	30
Авто зам	25
Нисэх буудал	25
Цахилгаан холбоо	15
Үйлдвэрлэл	10
Бусад үйлчилгээ	15

- 4.1.7. **Үе шат 7. Санхүүгийн хорогдуулалтын хувийг (financial discount rate - FDR) тодорхойлох.** УХОХ-т хөтөлбөрт тусгах хөрөнгө оруулалтын төслүүдэд ашиглах санхүүгийн хорогдуулалтын хувийг Үндэсний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага салбарын онцлог, санхүүжилтийн эх үүсвэрийг харгалзан тодорхойлох ба үечилсэн байдлаар шинэчилж байна.

Хорогдуулалтын хувь өндөр байх тусам өнөөгийн цэвэр үнэ цэнэ багасдаг, эсрэг тохиолдол ихэсдэг урвуу хамааралтай. Тиймээс хөрөнгө оруулалтын төслийг өнөөгийн цэвэр үнэ цэнийн аргаар үнэлэхэд хорогдуулалтын хувийг ямар үндэслэлээр хэдэн хувиар сонгон авсан бэ? гэдэг нь хувилбарын оновчтой сонголт болоод хөрөнгө оруулалтын төслийн эцсийн үр дүнд ихээхэн нөлөөлдөг. Мөн хорогдуулалтын хувийг ямар хувиар авснаас хамаарч өнөөгийн үнэ цэнийн агуулга өөр өөр болдог. Иймээс хорогдуулалтын хувийг тухайн хөрөнгө оруулалтын зорилго, шинж чанар, зах зээлийн нөхцөл байдал зэргээс хамааруулан сайтар судалсны үндсэн дээр бодитой тогтоож шинжилгээг хийх шаардлагатай. Хорогдуулалтын хувь нь инфляциас өндөр байх ёстой ба

Хорогдуулалтын хувийг хэд хэдэн янзаар тооцдог хэдий ч дараах аргуудыг түгээмэл ашигладаг. Үүнд:

- Капиталын жигнэсэн дундаж өртөг – Төслийг хэд хэдэн эх үүсвэрээс санхүүжүүлэх үед хорогдуулалтын хувийг компанийн капиталын жигнэсэн дундаж өртгийн хувиар авах нь зохимжтой байдаг бөгөөд энэ нь нэлээд үндэслэлтэй хорогдуулалтын хувь болдог.

$$WACC = \sum_{i=1}^n r_n \times MV_n$$

Энд:

WACC – Капиталын жигнэсэн дундаж өртөг. Нийт эх үүсвэрийн өртөг

r_n – Тухайн эх үүсвэрийн нийт санхүүжилтэд эзлэх хувь

MV_n – Тухайн эх үүсвэрийн шаардлагатай өгөөжийн хувь хэмжээ /хүүгийн хувь хэмжээ

n – Эх үүсвэрийн тоо

Тайлбар: WACC тооцохдоо өр, зээлээр санхүүжсэн тохиолдолд татварыг хасч тооцохыг анхаарна уу

Жишээлбэл: $WACC = r_1 \times MV_1 + r_2 \times MV_2 \times (1 - \text{татварын хувь})$

- Зээлийн хүүгийн хувь – Хөрөнгө оруулалтын төслийг зээлээр санхүүжүүлэх нөхцөлд хорогдуулалтын хувийг уг зээлийн хүүгийн хувиар авах нь зохимжтой.
 - Банкны хадгаламж, засгийн газар, төв банкны үнэт цаасны хүүгийн хувь – Капиталын жигнэсэн дундаж өртөг болон нөхцлүүдийн хүүг нарийн тогтоох боломжгүй нөхцөлд эрсдэл багатай, найдвартай эх үүсвэр болох банкны хадгаламж, засгийн газар, төв банкны үнэт цаас зэрэг хөрөнгө оруулалтын хүүгийн хувийг ашиглах нь тохиромжтой. Дэд бүтцийн төслүүдийг ихэвчлэн засгийн газрын бондын хүүгээр тооцдог.
 - Зах зээлийн өгөөжийн дундаж хувь – Зах зээлийн дундаж өгөөжөөс их өгөөж өгөх хөрөнгө оруулалтын хувилбарыг хэрэгжүүлнэ гэсэн шалгуур тавих нөхцөлд уг хувийг ашиглах бөгөөд энэ нь нилээд өндөр шалгуур болдог.
- 4.1.8. **Үе шат 8.** Санхүүгийн загварыг боловсруулж, төслийн мөнгөн урсгалын төсөөллийг хийх. Төслийн санхүүгийн орлого, зардлын тооцоолол, санхүүжилтийн хуваарь, эх үүсвэрийн төлөвлөлт зэрэгт үндэслэн санхүүгийн загварыг боловсруулж, төслийн мөнгөн урсгалын төсөөллийг Хавсралт 5-д үзүүлсэн загварын дагуу хийнэ. Төсөл үргэлжлэх жил тутмын мөнгөн урсгалыг үйл ажиллагааны, санхүүгийн, хөрөнгө оруулалтын гэсэн төрөл тус бүрийн хувьд тодорхойлж, тухайн жилийн цэвэр мөнгөн урсгал, хуримтлагдсан мөнгөн урсгалыг тооцоолно. Өнөөдрийн нэг төгрөг ирээдүйн нэг төгрөгтэй тэнцдэггүй, өнөөдрийн нэг төгрөгийг хэрхэн зөв зарцуулснаас ирээдүйн орлого, ашгийн хэмжээ хамаардаг тул мөнгөн урсгалын төсөөллийг гаргахдаа мөнгөний өнөөгийн үнэ цэнийг тусгадаг. Ингэж тооцоолохдоо үе бүрийн мөнгөн гүйлгээ тэр үеийнхээ эцэст хийгдэнэ гэсэн нөхцлөөр тооцооллыг хялбарчилж болно.
- 4.1.9. **Үе шат 9.** Санхүүгийн тогтвортой байдлыг шинжлэх. Хэрэв төсөл нь ирээдүйд бэлэн мөнгөний дутагдалд орох эрсдэл байхгүй бол төслийг санхүүгийн хувьд чадамжтай гэж үзнэ. Өөрөөр хэлбэл хэрэв төслийн он дамжсан хуримтлалаар бий болсон мөнгөн урсгалын нийлбэр нь төслийн хэрэгжилтийн бүх жилүүдэд эерэг үзүүлэлттэй бол төслийг санхүүгийн чадамжтай гэж үзнэ. Хэрэв төслийн хуримтлагдсан мөнгөн урсгал жил бүр нь сөрөг гарч байвал санхүүжүүлэх эх үүсвэрийн сонголтыг өөрчлөх, эх үүсвэрийн нөхцөлийг өөрчлөх эсхүл улсын төсвөөс тодорхой хэмжээний татаас авах, улсын төсвөөс санхүүжүүлэх гэх мэтээр эх үүсвэрийн төлөвлөлтийг өөрчлөн мөнгөн урсгалын төсөөлөлд залруулга хийнэ.
- 4.1.10. **Үе шат 10.** Санхүүгийн үр ашгийн үзүүлэлтүүдийг тооцох. Энэхүү шинжилгээг хийхэд хамгийн түгээмэл ашиглагддаг төслийн үр ашгийг илэрхийлэгч үзүүлэлтүүд, тэдгээрийг хэрхэн тооцоолохыг Хавсралт 6-с харна уу. Тухайн төслийн онцлогоос хамааран санхүүгийн үр ашгийг тооцох үзүүлэлтүүдийг сонгох хэдий ч ихэвчлэн мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг тооцсон 4-с доошгүй үзүүлэлтээр төслийн үр ашгийг тодорхойлно.
- 4.1.11. **Үе шат 11.** Төслийн хөрөнгө оруулалтын өгөөж, санхүүгийн үр ашгийг илэрхийлэгч үзүүлэлтүүдийн үр дүнг Хавсралт 7-д үзүүлсэн маягтын дагуу нэгтгэн, дүгнэлт гаргана.
- 4.2. Энэхүү шинжилгээг төсөл санаачлагч хийж, үр дүнг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах “Төслийн санал”-даа оруулан Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

**ТАВ. ТӨСЛҮҮДИЙГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨГӨӨЖ, САНХҮҮГИЙН ҮР АШГИЙГ
ҮНДЭСЛЭН ЭРЭМБЭЛЭХ, СОНГОХ**

- 5.1. Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төслүүдийг харьцуулан эрэмбэлэх үүднээс Төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсэн санхүүгийн үр ашгийн шинжилгээний үр дүнг Хавсралт 8-д үзүүлсэн маягтын дагуу нэгтгэнэ.
- 5.2. Төслүүдийн санхүүгийн үр ашгийн үзүүлэлт тус бүрийн утгыг хооронд нь харьцуулж 1-5 оноогоор үнэлнэ. Энд хамгийн боломжит сайн утгатай төсөлд 5 оноо, хамгийн муу төсөлд 1 оноо өгч, төсөл тус бүрийн нийлбэр оноог тооцно.
- 5.3. Хавсралт 9-д үзүүлсэн маягтын дагуу нийлбэр оноо хамгийн өндөртэй төслийг нэгд жагсаах байдлаар эрэмбэлнэ.
- 5.4. Энэхүү шинжилгээний үр дүнд тодорхойлогдсон эрэмбийн дундаж оноо өндөртэй төслүүдийн санхүүжилтийн тогтвортой байдал, санхүүжилтийн эх үүсвэр амлагдсан эсэхийг харгалзан төсвийн тухай хууль, өрийн удирдлагын тухай хууль, төсвийн хүрээний мэдэгдэл, гадаад өрийн зохистой түвшин болон бусад холбогдох хууль, тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн сонгож улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгахаар санал болгож болно.
- 5.5. Мөн “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох, хэрэгжилтэд хяналт тавих аргачлал” II дагуу тоолийг үнэлэх “Хэрэгжих боломж” ерөнхий үзүүлэлтийн 2.5 дах үндсэн шалгуур үзүүлэлтийн үнэлгээнд ашиглана.

---oOo---

Анхны хөрөнгө оруулалт нь үндсэн хөрөнгө (биет, биет бус хөрөнгө), эргэлтийн хөрөнгө, төслийн бэлтгэл ажиллагааны дараах зардлаас бүрдэнэ. Үүнд:

- *Төлөвлөлт, бэлтгэл үйл ажиллагаатай холбоотой зардлууд* – суурь судалгаа, ТЭЗУС, ТЭЗҮ, дизайн, төлөвлөлт, зураг төсөв, инженерийн судалгаанууд, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон бусад холбогдох судалгаа, төлөвлөлтийн зардлууд, энэ үе шатны санхүүжилтийн өртөг, тухайн төсөлтэй холбоотой гарсан томилголт, цалин гэх мэт үйл ажиллагаа, удирдлагын бүх зардлууд, боловсон хүчин бэлтгэх, бүтээн байгуулалтын үеийн даатгал, төслийг эхлүүлэхтэй холбоотой эрх зүйн туслалцаа авах, бичиг баримт бүрдүүлэхтэй холбоотой эрх зүйн төлбөр г.м. зардлуудыг оруулан тооцно.
- *Барилга, байгууламжтай холбоотой зардлууд* – газар худалдан авах, газрын нөхөн төлбөр төлөх, газар чөлөөлөлттэй холбоотой зардлууд, барилга байгууламжийг барих зардлыг төлөвлөлтийн шийдэл болон холбогдох норм дүрэм, стандартын дагуу урьдчилсан байдлаар тооцно.
- *Дэд бүтэцтэй холбоотой зардлууд* – ус, цахилгаан, дулаан, ариутгах татуурга, мэдээлэл холбоо гэх мэт дэд бүтцийг шинээр байгуулах, шинэчлэн сайжруулах, өргөтгөх, засварлахтай холбоотой зардлуудыг дэд бүтцийн төлөвлөлт, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм дүрэм, стандартын дагуу урьдчилсан байдлаар тооцно.
- *Тээврийн хэрэгсэл, үндсэн үйл ажиллагааны техник, тоног төхөөрөмжтэй холбоотой зардлууд /Үйл ажиллагаа явуулах үндсэн тоног төхөөрөмж/* - тоног төхөөрөмж, техник хэрэгслийг худалдан авах үнэ, захиалга, нийлүүлэлт, тээвэрлэлт, угсралт, сургалтын гэх мэт захиалга хийхээс суурилуулж ашиглахад бэлэн болох хүртэл зардлыг нэмсэн дүнгээр тооцно. /Үндсэн хөрөнгө/
- *Компьютер, бусад техник хэрэгсэл, тавилга, эд хогшил /Үндсэн үйл ажиллагаа явуулахад туслах тоног төхөөрөмж/* - худалдан авах үнэ дээр суурилуулж ашиглахад бэлэн болох хүртэл зардлыг нэмсэн дүнгээр тооцно. /Үндсэн хөрөнгө/
- *Биет бус хөрөнгө* - Төслийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай тусгай зөвшөөрөл, зохиогчийн эрх, программ хангамж, патент зэргийг үнэлэн энд оруулан тооцно.
- *Санхүүжилтийн өртөг* - Анхны хөрөнгө оруулалттай холбогдон гарсан зээл, бондын хүүгийн зардлыг оруулан тооцож болно.
- *Эргэлтийн хөрөнгийн зардал* - Барилга, байгууламж ашиглалтад орсноос хойших шилжилтийн үеийн 6 хүртэлх сар, үйл ажиллагаа эхэлснээс хойших эхний 12 хүртэлх сарын үйл ажиллагааны зардлын санхүүжилтыг хөрөнгө оруулалтын зардалд оруулан тооцно.
- Хэрэв төслийн хөрөнгө оруулалтад өөрсдийн өмнө ашиглаж байсан хөрөнгө болон бусдаас авсан хуучин хөрөнгүүдийг ашиглах бол үлдэгдэл өртгөөр тооцон хөрөнгө оруулалтын зардалд оруулах ба тэдгээрийг тээвэрлэх, сэргээн засварлах, суурилуулахтай холбоотой бүхий л зардлууд орно.
- Хэрэв одоо үйл ажиллагаагаа явуулж байгаа бол бүтээн байгуулалтын ажлууд дуусаж, шинэ барьсан, өргөтгөсөн эсхүл засварласан барилга, байгууламжууд ашиглалтад орох хүртэл гарах түр дэд бүтцийн ашиглалт, нүүлгэн шилжүүлэлт, үйл ажиллагаагаа түр явуулахтай холбоотой зардлууд, мөн өөрчлөлтийн зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой ажилтнуудын шинэ тоног төхөөрөмжийн сургалт, нээлтийн сурталчилгаа, танилцуулга, хэвлэл, тохижилт, арга хэмжээний г.м. зардлууд.

Анхны хөрөнгө оруулалтын тооцоолол

№	Үндсэн ажлууд	Нийт хөрөнгө оруулалт, сая төг	Төлөвлөж буй санхүүжилтийн эх үүсвэрийн төрөл	Урьдчилсан санхүүжилт хийгдсэн эсэх	Шаардлагатай санхүүжилт, сая төг				Тайлбар
					Суурь жил	Нэг дэх жил	Хоёр дах жил	п дэх жил	
1	Төлөвлөлт, бэлтгэл үйл ажиллагаатай холбоотой зардлууд		Ж: Санхүүжилтийн эх үүсвэр						
2	Барилга, байгууламжтай холбоотой зардлууд								
3	Дэд бүтэцтэй холбоотой зардлууд								
4	Тээврийн хэрэгсэл, үндсэн үйл ажиллагааны техник, тоног төхөөрөмжтэй холбоотой зардлууд								
5	Компьютер, бусад техник хэрэгсэл, тавилга, эд хогшил								
6	Биет бус хөрөнгө								
7	Санхүүжилтийн өртөг								
8	Эргэлтийн хөрөнгийн зардал								
	Нийт								

Газар, барилга байгууламж, дэд бүтцийн хөрөнгө оруулалт

№	Газар, барилга байгууламж, дэд бүтэц	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ, оял.тог	Нийт үнэ, сая.төг
1	Газар				
2	Газрын нөхөн төлбөр, газар чөлөөлөлттэй холбоотой зардлууд,				
3	Барилга байгууламжийн зардал				
4	Дэд бүтэцтэй холбоотой зардал				
				
	Нийт дүн				

Тоног төхөөрөмж, тавилга, эд хогшлийн хөрөнгө оруулалт				
№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо хэмжээ, ширхэг	Нэгж үнэ, сая.төг	Нийт үнэ, сая.төг
1	Үндсэн үйл ажиллагааны техник, тоног төхөөрөмжтэй холбоотой зардлууд			
2	Тээврийн хэрэгсэл			
3	Компьютер, бусад техник хэрэгсэл			
4	Тавилга, эд хогшил			
	Нийт			
Төсөвт өртөг				
Импортын татвар (VAT+Import tariff) 25.5 %				
НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ				

Бусад хөрөнгө оруулалт						
№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ, сая.төг	Нийт үнэ, сая.төг	Тайлбар
1	Төлөвлөлт, бялтгэл үйл ажиллагаатай холбоотой зардлууд					
2	Биет бус хөрөнгө					
3	Санхүүжилтийн өртөг					
4	Эргэлтийн хөрөнгийн зардал					
5						
7	Бусад - 10%					
	Нийт дүн					

Хэвсралт 2. Төслийн зардлын тооцоолол

Үйл ажиллагааны зардал						
№	Зардлын ангилал	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгж зардал, хоногт, сая.төг	Нийт зардал, жилд, сая.төг	Тайлбар
1	Тогтмол зардал	Цахилгааны зардал				
2		Цэвэр, бохир ус /халуун, хүйтэн/				
3		Халаалт г.м.				
4						
Нийт тогтмол зардлын дүн						
4	Хувьсах зардал	Харилцаа, холбооны зардал				
5		Харуул, хамгаалалтын зардал				
6		Шуудан холбооны зардал				
7		Бичиг хэргийн зардал				
8		Томилолтын зардал /дотоод, гадаад/				
9		Засвар, үйлчилгээний зардал				
10		Бусдаар гүйцэтгүүлэх зардал				
11		Мэдээлэл, сурталчилгааны зардал				
12		Тээвэр, шатахууны зардал				
13		Бусад зардал				
14						
15					
16 гэх мэт					
Нийт хувьсах зардлын дүн						
НИЙТ						

Элэгдлийн тооцоо							
№	Үзүүлэлт	Нэг дэх жил, сая.төг	Хоёр дах жил, сая.төг	Гурав дах жил, сая.төг	п дэх жил, сая.төг	Тайлбар
1	Барилга, байгууламж						
2	Тоног төхөөрөмж						
3	Бусад						
4						
Нийт дүн							

Материалын зардлын тооцоо				
Ашиглалтанд орсноос хойш				
№	Үзүүлэлт	Нэгж зардал, хоногт, сая.төг	Нийт зардал, жилд, сая.төг	Тайлбар
1	Материалын зардал			
2				
3				
Нийт				

Цалингийн сан									
№	Албан тушаал	Орон тоо	Үндсэн цалин	Нэмэгдэл цалин	Нэг ажилтны сарын цалин	Нийт дүн /сая төг/	НДШ, ЭМД	Нийт цалингийн хэмжээ /сар/	Нийт цалингийн хэмжээ /жил/
НИЙТ									

	Нэг дэх жил, сая.төг	Хоёр дах жил, сая.төг	Гурав дах жил, сая.төг	п дэх жил, сая.төг
Нийт цалингийн сан	-	-	-	-	-

Нийт зардлын тооцоо							
№	Үзүүлэлт	Нэг дэх жил, сая.төг	Хоёр дах жил, сая.төг	Гурав дах жил, сая.төг	п дэх жил, сая.төг	Тайлбар
1	Цалингийн зардал /НДШ, ЭМД орсон/						
2	Үйл ажиллагааны зардал						
3	Материалын зардал						
4	Элэгдлийн зардал						
5	Бусад зардал						
	Нийт дүн						

Хавсралт 3. Төслийн орлогын тооцоолол

Нийт орлогын тооцоо																
	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хүчин чадал, өдөрт	Нэг дэх жил			Хоёр дах жил			Гурав дах жил			n дэх жил			Тайлбар
				Хүчин чадал ашиглалт, %	Нэгж орлого, хоногт, сая.төг	Нийт орлого, жилд, сая.төг	Хүчин чадал ашиглалт, %	Нэгж орлого, хоногт, сая.төг	Нийт орлого, жилд, сая.төг	Хүчин чадал ашиглалт, %	Нэгж орлого, хоногт, сая.төг	Нийт орлого, жилд, сая.төг	Хүчин чадал ашиглалт, %	Нэгж орлого, хоногт, сая.төг	Нийт орлого, жилд, сая.төг	
1	Орлогын эх үүсвэр 1															
2	Орлогын эх үүсвэр 2															
3	Орлогын эх үүсвэр 3															
	Нийт															

Орлого, үр дүнгийн тайлан					
Д/Д	Үзүүлэлтүүд	Нэг дэх жил, сая.төг	Хоёр дах жил, сая.төг	Гурав дах жил, сая.төг	п дэх жил, сая.төг
Нийт орлого					
1	Орлогын эх үүсвэр 1				
2	Орлогын эх үүсвэр 2				
3	Орлогын эх үүсвэр 3				
				
	Нийт орлого				
Нийт зардал					
1	Тоног төхөөрөмжийн зардал				
2	Үйл ажиллагааны зардал				
3	Цалингийн зардал				
4	Элэгдлийн зардал				
5	Материалын зардал				
6				
	Нийт зардал				
	Үндсэн үйл ажиллагааны ашиг				
Үйл ажиллагааны бус зардал					
1	Зээлийн хүүгийн зардал				
2	Үйл ажиллагааны бус зардлын дүн				
1	Татварын өмнөх ашиг, алдагдал				
2	Ашгийн татвар (10%)				
3	Татварын дараах цэвэр ашиг				
4	Цэвэр ашгийн хувь, %				

Хавсралт 4. Төслийн санхүүжилтийн хуваарь

Санхүүжилтийн төлөвлөгөө									
№	Зорилтууд	Нийт хөрөнгө оруулалт, сая төг	Төлөвлөж буй санхүүжилтийн эх үүсвэр	Урьдчилсан санхүүжилт хийгдсэн эсэх	Шаардлагатай санхүүжилт, сая төг				Тайлбар
					Суурь жил	Нэг дэх жил	Дөрөв дэх жил	
1	Зорилт 1		Санхүүжилтийн эх үүсвэр						
2	Зорилт 2								
3	Зорилт 3								
4								
Нийт									

Хавсралт 5. Төслийн мөнгөн урсгалын төсөөлөл

Мөнгөн урсгалын төрөл	... он	... он
Үйл ажиллагааны мөнгөн урсгал		
Мөнгөн орлогын дүн	Σ мөнгөн орлого	Σ мөнгөн орлого
Мөнгөн зарлагын дүн	Σ мөнгөн зарлага	Σ мөнгөн зарлага
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн урсгал	Σ мөнгөн орлого - Σ мөнгөн зарлага	Σ мөнгөн орлого - Σ мөнгөн зарлага
Санхүүгийн мөнгөн урсгал		
Мөнгөн орлогын дүн	Σ мөнгөн орлого	Σ мөнгөн орлого
Мөнгөн зарлагын дүн	Σ мөнгөн зарлага	Σ мөнгөн зарлага
Санхүүгийн цэвэр мөнгөн урсгалын дүн	Σ мөнгөн орлого - Σ мөнгөн зарлага	Σ мөнгөн орлого - Σ мөнгөн зарлага
Хөрөнгө оруулалтын мөнгөн урсгал		
Мөнгөн орлогын дүн	Σ мөнгөн орлого	Σ мөнгөн орлого
Мөнгөн зарлагын дүн	Σ мөнгөн зарлага	Σ мөнгөн зарлага
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн урсгал дүн	Σ мөнгөн орлого - Σ мөнгөн зарлага	Σ мөнгөн орлого - Σ мөнгөн зарлага
Цэвэр мөнгөн урсгал	ЦМУ1 = YAЦМ + CЦМ + XOЦМ	ЦМУ2 = YAЦМ + CЦМ + XOЦМ
Хуримтлагдсан мөнгөн урсгал	ЦМУ1	ЦМУ1 + ЦМУ2

Хавсралт 6. Төслийн санхүүгийн үр ашгийн шалгуур үзүүлэлтүүд

№	Шалгуур үзүүлэлт	Товчлол	Тодорхойлолт	Тооцох томьёо
Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ тооцдоггүй үзүүлэлтүүд				
1	Эргэн төлөгдөх хугацаа – Payback Period	PP	Эргэн төлөгдөх хугацаа гэдэг нь төслөөс олсон орлогоороо зарцуулсан зардлаа нөхөх, шаардагдах хугацааг хэлнэ. Энэ нь хөрөнгө оруулалтын төслөөс олох жил бүрийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн орлого нь төсөлд оруулсан анхны хөрөнгө оруулалтын зардлыг хэдийд бүрэн нөхөх цаг хугацааг харуулдаг.	$PP = n + \frac{I_0 - \sum_{t=1}^n CF_t}{\sum_{t=1}^n CF_{t+1}}$ $I_0 = \sum_{t=0}^n \frac{IC_t}{(1+i)^t}$ <p>Энд: <i>n</i>: Зардлаа бүрэн нөхөн төлж болох хугацааны өмнөх жилийн тоо $\sum_{t=1}^n \frac{CF_t}{(1+i)^t}$: <i>t</i> жилийн цэвэр мөнгөн урсгалын нийлбэр $\sum_{t=1}^n \frac{CF_{t+1}}{(1+i)^{t+1}}$: <i>t</i> + 1 жилийн цэвэр мөнгөн урсгалын нийлбэр</p>
2	Ашгийн нормын арга – Accounting Rate of Return	ARR	Энэ аргын мөн чанар нь жилийн дундаж цэвэр ашгийн хэмжээнд шаардагдах хөрөнгө оруулалтын зардлын хэмжээг тодорхойлох буюу эдгээрийг харьцуулах замаар ашгийн нормыг үнэлэхэд оршино. Өөрөөр хэлбэл тухайн жилд бэлэн ашиглагдаж байгаа бодит хөрөнгийн өгөөж буюу дансаар байгаа хөрөнгийн ашиглалтын түвшнийг харуулдаг.	$ARR = \frac{ANP}{I_0}$ <p>Энд: <i>ARR</i> – Ашгийн нормын хувь <i>ANP</i> – Жилийн дундаж цэвэр ашиг (Average Net Profit) <i>I</i>₀ – Анхны хөрөнгө оруулалт (Initial Investment)</p>
3	Хөрөнгө оруулалтын өгөөж – Return on Investment	ROI	Хөрөнгө оруулалтын харьцаагаар тодорхойлдог бөгөөд уг арга нь тухайн ашиглагдсан хөрөнгийн төгрөг хэчнээн ашиг олсноор нь үнэлдэг.	$ROI = \frac{NP}{I_0}$ <p>Энд: <i>ROI</i> – Хөрөнгө оруулалтын өгөөж <i>NP</i> – Цэвэр ашиг (Net Profit) <i>I</i>₀ – Анхны хөрөнгө оруулалт (Initial Investment)</p>
Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ тооцдог үзүүлэлтүүд				
4	Цэвэр өнөөгийн үнэ цэнэ – Net Present Value	NPV	Цэвэр өнөөгийн үнэ цэнэ нь төслийг хэрэгжүүлснээр орж ирэх мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ ба төслийн анхны хөрөнгө оруулалтын хоорондох зөрүүгээр тодорхойлогдоно.	$NPV = \sum_{t=1}^n \frac{CF_t}{(1+r)^t} - I_0$ <p>Энд <i>CF</i>_{<i>t</i>}: төслийн хугацааны <i>t</i> агшинд орж цэвэр мөнгөн урсгал (Cash Flow) <i>I</i>₀: <i>t</i> хугацааны хөрөнгө оруулалтын зардал (Initial Cost) <i>i</i>: хорогдуулалтын хувь (Discount rate)</p>
5	Өгөөжийн дотоод хувь – Internal Rate of Return	IRR	Нөхөлтийн дотоод хувийн арга, өгөөжийн дотоод хувь, норм гэж мөн нэрлэдэг. Энэхүү арга нь төслөөс ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалуудын өнөөгийн үнэ цэнийг төслийн анхны хөрөнгө оруулалттай тэнцүү байлгахуйц хүүгийн хэмжээ юм.	$NPV = \sum_{t=1}^n \frac{CF_t}{(1+IRR)^t} - I_0 = 0$ <p>Энд <i>CF</i>_{<i>t</i>} – <i>t</i> жилийн цэвэр мөнгөн урсгал <i>IRR</i> – Өгөөжийн дотоод хувь <i>I</i>₀: <i>t</i> хугацааны хөрөнгө оруулалтын зардал (Initial Cost)</p>
6	Бодит өгөөжийн дотоод хувь – Modified	MIRR	IRR нь NPV=0 үед тодорхойлогддог боловч энэ тэнцэтгэл язгуургүй байх эсвэл тэр нь хэд хэд байх тохиолдол байдаг. Эдгээр нөлөөллийг арилгахын тулд дотоод өгөөжийн нормыг тооцох	$MIRR = \left[\frac{FV(PCF)}{PV(NCF)} \right]^{\frac{1}{n}} - 1$ $FV(PCF) = \sum_{t=0}^n CIF_t (1+i)^{n-t}$

	Internal Rate of Return		боловсронгуй арга буюу MIRR-ийг тодорхойлдог.	$PV(NCF) = \sum_{t=0}^n \frac{COF_t}{(1+i)^t}$ <p>Энд: <i>FV(PCF)</i> – Эерэг мөнгөн урсгалуудын ирээдүйн үнэ цэнэ (<i>Future Value of Positive Cash Flow</i>) <i>PV(NCF)</i> – Сөрөг мөнгөн урсгалуудын өнөөгийн үнэ цэнэ (<i>Present Value of Negative Cash Flow</i>) <i>COF_t</i> – Төслийн <i>t</i> хугацаанд төсөлд зарцуулах мөнгөний хэмжээ буюу төслийн гарах мөнгөн урсгалууд (<i>Cash Outflows</i>) <i>CIF_t</i> – Төслийн <i>t</i> агшинд хүлээн авах орлогын хэмжээ буюу төслийн орох мөнгөн урсгалууд (<i>Cash Inflows</i>) <i>i</i> – Капиталын нийт өртөг (шаардагдах өгөөж, хорогдуулалтын хувь гэж мөн нэрлэж болно.) MIRR – Бодит өгөөжийн дотоод хувь</p>
7	Хорогдуулсан эргэн төлөгдөх хугацаа – Discounted Payback Period	DPBP	Дискаунтчилагдсан эргэн төлөгдөх хугацаа гэдэг нь төсөлд зарцуулсан хөрөнгийг төслөөс хүлээн авах дискаунт (хорогдуулалт) тооцсон мөнгөн урсгалаар нөхөх, шаардагдах хугацаа юм.	$DPP = n + \frac{I_0 - \sum_{t=1}^n \frac{CF_t}{(1+i)^t}}{\sum_{t=1}^n \frac{CF_{t+1}}{(1+i)^{t+1}}}$ <p>Энд: <i>n</i> – Зардлаа бүрэн нөхөн төлж дуусах хугацааны өмнөх жилийн тоо $\sum_{t=1}^n DCF_t$ – <i>t</i> жилийн хорогдуулсан мөнгөн урсгал (<i>Discounted Cash Flow</i>) $\sum_{t=1}^n DCF_{t+1}$ – <i>t+1</i> жилийн хорогдуулсан мөнгөн урсгал</p>
8	Ашигт байдлын индекс – Profitability Index	PI	Ашигт ажиллагааны индексийг төслөөс ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг түүний анхны хөрөнгө оруулалтын хэмжээнд харьцуулах замаар тооцдог. Өөрөөр хэлбэл энэ арга нь хөрөнгө оруулалтын 1 төгрөг тутмаас хэдэн төгрөгийн орлого олж байгааг харуулдаг.	$PI = \frac{\sum_{t=1}^n \frac{CF_t}{(1+i)^t}}{I_0}$ <p>Энд: <i>PI</i> – Ашигт ажиллагааны индекс <i>CF_t</i> – <i>t</i> жилийн цэвэр мөнгөн урсгал <i>I₀</i> – Анхны хөрөнгө оруулалт (<i>Initial Investment</i>)</p>
9	Үр ашиг зардлын харьцаа – Benefit Cost Ratio	BCR	Үр ашиг, зардлын харьцаа нь төслийн үр ашиг ба зардлын өнөөгийн үнэ тус бүрийн харьцааг илэрхийлнэ.	$BCR = \frac{PV(PCF)}{PV(NCF)}$ <p>Энд: <i>PV(PCF)</i> – Эерэг мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ <i>PV(NCF)</i> – Сөрөг мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ</p>
10	Өнөөгийн үнэ цэнийн харьцаа – Present Value Ratio	PVR	Өнөөгийн үнэ цэнийн харьцаа (PVR) нь төслийн эдийн засгийн үнэлгээнд ашиглагдаж болох бөгөөд үүнийг одоогийн цэвэр үнэ цэнийг цэвэр сөрөг мөнгөн гүйлгээгээр хувааж болно.	$PVR = \frac{NPV}{PV(NCF)}$ <p>Энд: <i>NPV</i> – Цэвэр өнөөгийн үнэ цэнэ <i>PV(NCF)</i> – Сөрөг мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ</p>

Хавсралт 7. Төслийн санхүүгийн шинжилгээний үр дүн, дүгнэлт

Төслийн нэр: _____ Төсөвт өртөг: _____ сая.төг

№	Шалгуур үзүүлэлт	Товчлол	Шийдвэр гаргах нөхцөл	Утга
<i>Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ тооцдоггүй үзүүлэлтүүд</i>				
1	Эргэн төлөгдөх хугацаа	<i>PP</i>	Хэрэв төслийн эргэн төлөгдөх хугацаа нь төслийн нийт хугацаанаас бага байвал төслийг хэрэгжүүлж болно. Эргэн төлөгдөх хугацаа нь төсөл хэрэгжих нийт хугацаанаас их байх төслүүдийг хэрэгжүүлэхээс татгалзах нь зүйтэй.	
2	Ашгийн нормын арга	<i>ARR</i>	Энэ аргын үед ашгийн норм аль өндөртэй төслийг сонгож хэрэгжүүлнэ. Өөрөөр хэлбэл ашгийн нормоор нь зэрэгцүүлнэ.	
3	Хөрөнгө оруулалтын өгөөж	<i>ROI</i>	Санал болгосон бүх хөрөнгө оруулалтын төслийг санхүүжүүлэх эх үүсвэр хязгаарлагдмал, нэгээс олон тооны төсөл зорилтот түвшнээс өндөр өгөөжийн түвшинтэй байвал шалгуур хангасан төслүүдийг жагсааж хамгийн сайныг нь сонгон авахад энэ аргыг ашиглана.	
<i>Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ тооцдог үзүүлэлтүүд</i>				
4	Цэвэр өнөөгийн үнэ цэнэ	<i>NPV</i>	Тэгээс их байвал төслийг хэрэгжүүлж болно, тэгээс бага байвал уг төслийг хэрэгжүүлэхээс татгалзана.	
5	Өгөөжийн дотоод хувь	<i>IRR</i>	Хэрэв <i>IRR</i> нь капиталын өртгөөс их бол төслийг хэрэгжүүлнэ. <i>IRR</i> нь капиталын өртгөөс бага бол төслөөс татгалзана	
6	Бодит өгөөжийн дотоод хувь – Modified Internal Rate of Return	<i>MIRR</i>	Дотоод өгөөжийн түвшин <i>IRR</i> нь тогтвортой бус хоёрдмол шинж чанартай төслийг шинжлэхдээ он тус бүрийн цэвэр эргэлтийн сүүлийн хасах тэмдэгтэй гарсан зардлыг <i>MIRR</i> -аар тооцсон өнөөгийн үнэ цэнээр нь анхны хөрөнгө оруулалтын зардалтай нийлүүлэн <i>IRR</i> -ийн тооцоог хийхийг өгөөжийн түвшнийг тогтвортой болгон өөрчлөх буюу Modified <i>IRR</i> Analysis гэж нэрлэдэг. Өөрөөр хэлбэл сүүлийн жилүүдийн хасах гүйлгээг <i>MIRR</i> -аар тогтвортой болгон өөрчилж, <i>IRR</i> -ийн үнэлгээнд оруулна.	
7	Хорогдуулсан эргэн төлөгдөх хугацаа	<i>DPBP</i>	Энэ аргын мөн чанар нь эргэн төлөгдөх хугацааг тодорхойлохдоо төслөөс орох мөнгөн орлогуудыг хорогдуулалтын хувь хэмжээ (капиталын өртөг)-ийн тусламжтайгаар нэг сууринд оруулж зэрэгцүүлснээр эцсийн шийдвэр гаргахад оршино.	
8	Ашигт байдлын индекс	<i>PI</i>	Хэрэв ашигт ажиллагааны индекс нь 1-ээс их байвал төслийг сонгон хэрэгжүүлж болно. Харин ашигт ажиллагааны индекс нь 1-ээс бага тэнцүү байвал төслийг хэрэгжүүлэхээс татгалзах нь зүйтэй.	
9	Үр ашиг зардлын харьцаа	<i>BCR</i>	Хэрэв <i>BCR</i> нь 1-с их бол төсөл нь эдийн засгийн хувьд үр ашигтай байна. <i>IRR</i> -тай адил энэ харьцаа нь төслийн хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамаарахгүй	
10	Өнөөгийн үнэ цэнийн харьцаа	<i>PVR</i>	Энд $BCR - PVR = 1$ байх ба хэрэв <i>PVR</i> нь тэгээс их бол төсөл нь эдийн засгийн хувьд үр ашигтай тул хэрэгжүүлж болно. Харин тэгээс бага бол эдийн засгийн хувьд үр ашиггүй гэж үзнэ.	

Дүгнэлт:

Албан хаагч: _____ / _____ /

Эрх бүхий албан тушаалтан: _____ / _____ /

Огноо:

Хавсралт 8. Төслүүдийн санхүүгийн үр ашгийн үзүүлэлтүүдийн нэгтгэл

№	Төслийн нэр	NPV	DPBP	IRR	PI	MIRR	DPBP	BCR
1	Төсөл 1	Утга							
2	Төсөл 2								
3	Төсөл 3								
4								
5	Төсөл n								

№	Төслийн нэр	NPV	DPBP	IRR	PI	MIRR	DPBP	BCR	Нийлбэр оноо
1	Төсөл 1	Оноо								
2	Төсөл 2									
3	Төсөл 3									
4									
5	Төсөл n									

Тайлбар: Энд хамгийн боломжит сайн утгатай төсөлд 5 оноо, хамгийн муу төсөлд 1 оноо өгнө.

Албан хаагч: _____ / _____ /

Эрх бүхий албан тушаалтан: _____ / _____ /

Огноо:

Хавсралт 9. Төслийн эрэмбийн хүснэгт

№	Төслийн нэр	Нийлбэр оноо	Эрэмбэ	Тайлбар
1	Төсөл 1	Мах Оноо	1	
2	Төсөл 2			
3	Төсөл 3			
4			
5	Төсөл n			

Албан хаагч: _____ / _____ /

Эрх бүхий албан тушаалтан: _____ / _____ /

Огноо: